



200

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/111

Улаанбаатар хот

Шалгуур үзүүлэлт батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 374 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид олгох мэргэшлийн зэргийн шалгуур үзүүлэлт”-ийг хавсралтаар баталсугай.
2. Онцгой байдлын байгууллагын хэмжээнд мэргэшлийн зэргийн шалгалтыг 2019 оны 3 дугаар улиралд багтаан зохион байгуулж, дүнг илтгэхийг Захиргааны удирдлагын газар (хурандаа Л.Болдбаатар)–т үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тэргүүн дэд дарга (бригадын генерал Г.Ариунбуян)-д даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2019 оны 07 дүгээр сарын 11-ны өдрийн
А/111... дугаар тушаалын хавсралт

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИД ОЛГОХ
МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Нэг. Зорилго:

Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн мэдлэг, ур чадвар, нийгмийн асуудлыг дээшлүүлэх, "Онцгой байдлын байгууллагын алба хаагчид мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журам"-ыг хэрэгжүүлэхэд оршино.

Хоёр. Алба хаагчдад тавигдах шаардлага:

Онцгой байдлын байгууллагад 4-өөс доошгүй жил ажилласан офицер, ахлагч мэргэшлийн III зэргийн, онцгой байдлын байгууллагад 8-аас доошгүй жил ажилласан, эсхүл мэргэшлийн III зэрэг авснаас хойш 2 жил тухайн мэргэжлээрээ ажиллаж, мэргэшлийн зэргээ амжилттай хамгаалсан алба хаагч мэргэшлийн II зэргийн, онцгой байдлын байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан, эсхүл мэргэшлийн II зэрэг авснаас хойш 3 жил тухайн мэргэжлээрээ ажиллаж, мэргэшлийн зэргээ амжилттай хамгаалсан алба хаагч мэргэшлийн I зэргийн шалгалтад орох эрхтэй. Ажилласан жилд байгууллагын захиалгаар гадаад, дотоодын академи, их, дээд сургуульд сурсан хугацааг оруулж тооцно. Эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж тэнцсэн эсэх талаарх дүгнэлт (ТТАХНЭ болон аймгийн нэгдсэн эмнэлэг) авсан байна.

Гурав. Мэргэшлийн зэргийн шатлал:

Мэргэшлийн зэргийн шалгалтын багц шалгалт бүрээс 60 хувь түүнээс дээш оноо авсан тохиолдолд III зэргийн шалгалтад тэнцсэнд тооцно. Нэг багц шалгалтад 59 хувь буюу түүнээс доош оноо авсан тохиолдолд тэнцээгүйд тооцно.

Мэргэшлийн III зэргийг хамгаалах шалгалтад 76 хувь түүнээс дээш оноо авсан тохиолдолд III зэргийг хамгаалж, II зэргийн шалгалтад тэнцсэнд тооцно. Шалгалтад 70-75 хувь авсан тохиолдолд III зэргийг хамгаалсанд тооцно. Нэг багц шалгалтад 69 хувь буюу түүнээс доош оноо авсан тохиолдолд тэнцээгүйд тооцож зэргийн нэмэгдлийг олгохгүй ба урьд авсан зэргийг цуцална.

Мэргэшлийн II зэргийг хамгаалах шалгалтад 80 хувь түүнээс дээш оноо авсан тохиолдолд II зэргийг хамгаалж, I зэргийн шалгалтад тэнцсэнд тооцно. Шалгалтад 70-79 хувь авсан тохиолдолд II зэргийг хамгаалсанд тооцно. Нэг багц шалгалтад 69 хувь буюу түүнээс доош оноо авсан тохиолдолд тэнцээгүйд тооцож III зэргийн нэмэгдлийг олгоно.

Мэргэшлийн I зэргийг хамгаалах шалгалтад 80 хувь түүнээс дээш оноо авсан тохиолдолд хамгаалсанд тооцно. Нэг багц шалгалтад 79 хувь буюу түүнээс доош оноо авсан тохиолдолд тэнцээгүйд тооцож II зэргийн нэмэгдлийг олгоно.

Тайлбар: Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу мэргэшлийн зэргийн шалгалтад (мэргэшлийн зэрэггүй) хамрагдаж байгаа алба хаагч тухайн шалгалтад тэнцээгүй тохиолдолд шатлал бууруулж мэргэшлийн зэрэг олгохгүй. Мэргэшлийн зэрэгтэй алба хаагч шатлал алгасаж мэргэшлийн зэргийн шалгалтад орохгүй.

Дөрөв. Мэргэшлийн зэргийн ангилал, шатлал, мэргэжлийн төрөл, шалгалтын оноо:

| Д/д | Мэргэжлийн төрөл | Хамрагдах албан тушаал | 1. Ерөнхий мэдлэг (тестээр) | | | | | 2. Сэтгэл зүйн болон бие бялдарын бэлтгэлжилтийн түвшин (биеэр) | 3. Тусгай бэлтгэл (тест, биеэр) | | |
|---------------|--------------------------------|--|-----------------------------|----------------------------------|---------------------|-------------------------------------|------|---|---------------------------------|--------------------|------|
| | | | Хууль, тогтоомж | Гадаад хэл (англи, орос, чадвар) | Сэтгэн бодох чадвар | Компьютерын өргөн нөхөн хэрэглэлийн | Оноо | | Мэдлэг | Үр чадвар, Бэлтгэл | Оноо |
| Офицер | | | | | | | | | | | |
| 1. | Удирдах албан тушаалын офицер | ОБЕГ-ын удирдлага, газар, хэлтэс, төвийн дарга, Гамшиг судлалын хүрээлэнгийн захирал, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга, Үндэсний аврах бригадын захирагч, орлогч, Давтан сургалт, сэргээн заслын төвийн дарга, Аврагч биеийн тамир, техник-спортын хорооны дарга | 25 | 15 | 10 | 15 | 65 | 25 | 5 | 5 | 10 |
| 2. | Эрэн хайх, аврах ангийн офицер | Эрэн хайх, аврах анги, салбар, бүлэг, Тусгай (хими, тэсрэх, агаар, уулын) чиг үүргийн салбар, бүлгийн дарга, захирагч, Эрэн хайх, аврах нохойн албаны дарга, ахлах нохой сургагч, нохой сургагч, нисэх төхөөрөмжийн инженер, техникч | 20 | 10 | 10 | 10 | 50 | 30 | 10 | 10 | 20 |

109

| | | | | | | | | | | |
|---|----|----|----|----|----|----|----|----|----|----|
| Гал түймэр унтраах, аврах ангийн захирагч, салааны захирагч | 20 | 10 | 10 | 10 | 10 | 50 | 30 | 10 | 10 | 20 |
| Нөөцийн чиглэлийн офицер | 20 | 15 | 10 | 15 | 60 | 30 | 5 | 5 | 10 | 10 |
| Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | 30 | 10 | 10 | 15 | 65 | 25 | 5 | 5 | 10 | 10 |
| Гал түймрийн улсын хяналтын байцаагч | 30 | 10 | 10 | 15 | 65 | 25 | 5 | 5 | 10 | 10 |
| Холбоо, зарлан мэдээллийн чиглэлийн офицер | 20 | 20 | 10 | 20 | 70 | 20 | 5 | 5 | 10 | 10 |
| Гүйцэтгэх албан тушаалтан | 20 | 15 | 10 | 15 | 60 | 30 | 5 | 5 | 10 | 10 |
| Ахлагч | | | | | | | | | | |
| Аврагч | 10 | 5 | 5 | 5 | 25 | 35 | 5 | 5 | 35 | 40 |

| | | | | | | | | | | | | | | | | | | | |
|-------------------------------|--|---|----|----|----|----|----|----|----|----|----|----|--|--|--|--|--|--|--|
| | ажиллагааны салбар, Уул уурхайн аврах салбарын аврагч, аврагч-тэсэлгээчин, аврагч-усчин, аврагч-химичин, аврагч-нохой хөтлөгч, эмнэлэгийн зааварлагч, сургагч ахлагч, шүүхэрчин-нисэх төхөөрөмжийн нисгэгч, шүүхэрчин аврагч, десантчин аврагч, аврах багаж хэрэгслийн техникч, хэт хөнгөн онгоцны нисгэгч | | | | | | | | | | | | | | | | | | |
| | Гал сөнөөгч | 10 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 25 | 35 | 5 | 35 | 40 | | | | | | | |
| | Гал унтраах автомашины жолооч | 10 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 25 | 35 | 5 | 35 | 40 | | | | | | | |
| | Жолооч | 10 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 25 | 35 | 5 | 35 | 40 | | | | | | | |
| | Холбоо, зарлан мэдээллийн чиглэлийн ахлагч | 15 | 10 | 10 | 10 | 15 | 50 | 20 | 30 | 10 | 20 | 30 | | | | | | | |
| | Туслах албан тушаалтан | 20 | 5 | 5 | 5 | 5 | 35 | 30 | 35 | 10 | 25 | 35 | | | | | | | |
| Хууль, тогтоомж | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Удирдах албан тушаалын офицер | 1. Монгол Улсын Үндсэн хууль, 2. Төрийн албаны тухай хууль, 3. Гамшгаас хамгаалах тухай хууль, 4. Галын аюулгүй байдлын тухай хууль, 5. Улсын нөөцийн тухай хууль, 6. Цэргийн албаны тухай хууль, | Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, "Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам", "Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам", Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам, Улсын онцгой комиссын ажиллах журам, | | | | | | | | | | | | | | | | | |

| | | | |
|--|--|---|---|
| | | <p>7. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль, 8. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, 9. Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хууль, 10. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль, 11. Зэвсэгт хүчний тухай хууль, 12. Онц байдлын тухай хууль, 13. Захиргааны ерөнхий хууль 14. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, 15. Төрийн болон албаны нууцийн тухай хууль, 16. Хувь хүний нууцын тухай хууль, 17. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 18. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 19. Харилцаа холбооны тухай хууль, 20. Цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загвар, 21. Цэргийн нийтлэг дүрмүүд, 22. Онцгой байдлын байгууллагад алба хаах журам, 23. Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм</p> | <p>Мэргэжлийн ангийн дүрэм, Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх зохион байгуулалтын баримт бичиг боловсруулах журам, Онцгой байдлын байгууллагад төрийн болон албаны нууцийг ашиглах, хадгалах, хамгаалах журам, Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг хөтлөх журам, Улсын нөөцтэй холбогдолтой стандарт, дүрэм, журам, заавар, Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо</p> |
| | <p>Эрэн хайх, аврах ангийн офицер</p> | | <p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, "Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам", "Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам", Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам, Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх зохион байгуулалтын баримт бичиг боловсруулах журам, Онцгой байдлын байгууллагад төрийн болон албаны нууцийг ашиглах, хадгалах, хамгаалах журам, Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг хөтлөх журам, Эрэн хайх, аврах ажиллагааны холбогдолтой стандарт, дүрэм, журам, заавар</p> |
| | <p>Гал түймэр унтраах, аврах ангийн офицер</p> | | <p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, "Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам", "Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам", Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам, Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх зохион байгуулалтын баримт бичиг боловсруулах журам, Онцгой байдлын байгууллагад төрийн болон албаны нууцийг ашиглах, хадгалах, хамгаалах журам, Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг хөтлөх журам, Галын аюулгүй байдлын холбогдолтой стандарт, дүрэм, журам, заавар</p> |
| | <p>Нөөцийн чиглэлийн офицер</p> | | <p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, "Нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох журам" "Гамшгийн нөөцөөс бараа, материал захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх журам", "Гамшгаас хамгаалах хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах</p> |

журам” “Улсын нөөцийн эд хөрөнгийн хариуцлагын журам”, “Хүмүүнлэгийн багийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журам”, “Онцгой байдлын байгууллагын төв, орон нутаг дахь Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн анги, Улсын нөөцийн салбар, цэгийн агуулахын барилга байгууламж, техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах дунд хугацааны хөтөлбөр”, Улсын нөөцтэй холбогдолтой стандарт, дүрэм, журам, заавар

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”, Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам, Улсын онцгой комиссын ажиллах журам, Мэргэжлийн ангийн дүрэм, Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх зохион байгуулалтын баримт бичиг боловсруулах журам, Онцгой байдлын байгууллагад төрийн болон албаны нууцийг ашиглах, хадгалах, хамгаалах журам, Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг хөтлөх журам, Гамшгаас хамгаалах улсын хяналтын холбогдолтой стандарт, дүрэм, журам, заавар, Улсын нөөцтэй холбогдолтой стандарт, дүрэм, журам, заавар

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай хууль, Ойн тухай хууль, “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”, Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам, Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх зохион байгуулалтын баримт бичиг боловсруулах журам, Онцгой байдлын байгууллагад төрийн болон албаны нууцийг ашиглах, хадгалах, хамгаалах журам, Галын Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг хөтлөх журам, Галын аюулгүй байдлын холбогдолтой стандарт, дүрэм, журам, заавар

амшгаас
амгаалах
лсын
яналтын
айцаагч

ал түймрийн
лсын
яналтын
айцаагч

| | | | |
|-----|--|--|---|
| | Холбоо, зарлан мэдээллийн чиглэлийн офицер | | Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль, "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам", "Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам", "Холбоо зохион байгуулах журам" "Онцгой байдлын байгууллагад төрийн болон албаны нууцыг ашиглах, хадгалах, хамгаалах журам", "Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн ажиллах журам", Радио холбооны тайлбар толь MNS ITU-R R 573-3:2004, Мэдээллийн технологийн инженерийн ур чадвар, мэдээллийн технологийн нийтлэг мэдлэг MNS 5736:2007, Мэдээллийн технологийг ашиглах суурь чадвар MNS 6465:2014, Радио холбооны антен, фидерийн байгууламжид ажиллах аюулгүй ажиллагааны шаардлага MNS 6590:2016, Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн холбогдолтой стандарт, дүрэм, журам, заавар |
| | Гүйцэтгэх албан тушаалтан | | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, "Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам", "Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам", Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам, Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх зохион байгуулалтын баримт бичиг боловсруулах журам, Онцгой байдлын байгууллагад төрийн болон албаны нууцыг ашиглах, хадгалах, хамгаалах журам, Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг хөтлөх журам, Улсын нөөцтэй холбогдолтой стандарт, дүрэм, журам, заавар |
| 10. | Аврагч | 1. Монгол Улсын Үндсэн хууль, 2. Төрийн албаны тухай хууль, 3. Гамшгаас хамгаалах тухай хууль, 4. Галын аюулгүй байдлын тухай хууль, 5. Улсын нөөцийн тухай хууль, 6. Цэргийн албаны тухай хууль, | Эрэн хайх, аврах ажиллагааны холбогдолтой стандарт, дүрэм, журам, заавар |
| 11. | Гал унтраах автомашины жолооч | | Галын аюулгүй байдлын холбогдолтой стандарт, дүрэм, журам, заавар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм |

| | | |
|--------------------------------------|--|--|
| <p>Жолооч</p> | <p>7. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль, 8. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, 9. Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хууль, 10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 11. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 12. Цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загвар, 13. Цэргийн нийтлэг дүрмүүд, 14. Онцгой байдлын байгууллагад алба хаах журам, 15. Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм</p> | <p>Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль, "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам", "Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам", "Холбоо зохион байгуулах журам" "Онцгой байдлын байгууллагад төрийн болон албаны нууцыг ашиглах, хадгалах, хамгаалах журам", "Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн ажиллах журам", Радио холбооны тайлбар толь MNS ITU-R R 573-3:2004, Мэдээллийн технологийг ашиглах суурь чадвар MNS 6465:2014, Радио холбооны антен, фидерийн байгууламжид ажиллах аюулгүй ажиллагааны шаардлага MNS 6590:2016, Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн холбогдолтой стандарт, дүрэм, журам, заавар Онцгой байдлын байгууллагад төрийн болон албаны нууцийг ашиглах, хадгалах, хамгаалах журам,</p> |
| <p>Туслах албан тушаалтан</p> | <p>Сэтгэл зүйн болон бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин</p> | <p>Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийн нормативын шалгуур үзүүлэлтээр үнэлэх бөгөөд "А" үнэлгээ авсан тохиолдолд I зэргийг, "В" буюу түүнээс дээш үнэлгээ авсан тохиолдолд II зэргийг, "С" буюу түүнээс дээш үнэлгээ авсан тохиолдолд III зэргийг хамгаалсанд тооцно.</p> |
| <p>Удирдах албан тушаалын офицер</p> | <p>Мэдлэг</p> <p>Удирдахуйн ухааны онол, Архив албан хэрэг хөтлөлтийн стандарт, Эмнэлгийн анхны тусламж</p> | <p>Ур чадвар, Бэлтгэл</p> <p>I зэрэг: Тодорхой цагийн байдалд шийдвэр гаргах, Командлах ур чадвар, Байр зүйн зураг зурах, ажиллах, GPS төхөөрөмж ашиглан тодорхой хугацаанд цэгийг олох, Хүн нэг бүрийн хамгаалах (ОП-1) хэрэгслийг 3 минутанд өмсөх, Аврах олсоор дан давхар (эр, эм) уяаг 10 секундэд уях, Усанд сэлэлтийн өврөөр даллах төрлөөр 25 метр сэлэх II зэрэг: Тодорхой цагийн байдалд шийдвэр гаргах,</p> |

| | | |
|--|---|--|
| | | <p>Командлах ур чадвар, Байр зүйн зурагтай ажиллах, GPS төхөөрөмж ашиглан тодорхой хугацаанд цэгийг олох, Хүн нэг бүрийн хамгаалах (ОП-1) хэрэгслийг 3 минут, 20 секундэнд өмсөх, Аврах олсоор дан давхар (эр, эм) уяаг 15 секундэд уях, Усанд сэлэлтийн мэлхий төрлөөр 25 метр сэлэх, III зэрэг: Тодорхой цагийн байдалд шийдвэр гаргах, Командлах ур чадвар, Байр зүйн зураг унших, GPS төхөөрөмж ашиглан тодорхой хугацаанд цэгийг олох, Хүн нэг бүрийн хамгаалах (ОП-1) хэрэгслийг 4 минутанд өмсөх, Аврах олсоор дан давхар (эр, эм) уяаг 20 секундэд уях, Усанд сэлдэг байх</p> |
| <p>Эрэн хайх, Аврах ангийн фицер</p> | <p>Уснаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах журам, Уурхай, уулын үйлдвэр, үйлдвэрлэлийн аюултай обьектод аврах ажиллагааг зохион байгуулах журам, Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журам, Онцгой байдлын байгууллагын хэмжээнд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм, Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, Эмнэлгийн анхны тусламж</p> | <p>I зэрэг: Өгөгдсөн цагийн байдлыг үнэлж шийдвэр гаргах. Шаардлагатай хүч хэрэгслийн тооцоог гаргах, ажлын зурагт оруулах, Аврах олс, түгээтэй гоцроо /карбин/, олс гүйлгэгч, баавгайн савар /салаалагч/ дугуйтай дамар ашиглан 1 тонн ачааг 5 минутанд 2 метр газар татах Аврах ажиллагааны 8 төрлийн зангилааг уяж, хэрэглээ, зориулалтыг тайлбарлах, Усны гүнд 25 метр шумбах, живж буй иргэнийг аврах II зэрэг: Өгөгдсөн цагийн байдлыг үнэлж шийдвэр гаргах. Шаардлагатай хүч хэрэгслийн тооцоог гаргах, ажлын зурагт оруулах, Аврагчийн худрага, дуулга, бээлий, олсоор авирах, буух хэрэгсэл ашиглан 10 метр өндөр цамхагруу авирч, нэрвэгдэгчийг биедээ бэхэлж 5 минутанд буулгах техник, Аврах ажиллагааны 5 төрлийн зангилааг уяж, хэрэглээ, зориулалтыг тайлбарлах, Усанд сэлэлтийн өврөөр даллах төрлөөр 100 метр сэлэх</p> |

| | | | |
|--|--|---|---|
| | | | <p>III зэрэг: Өгөгдсөн цагийн байдлыг үнэлж шийдвэр гаргах. Шаардлагатай хүч хэрэгслийн тооцоог гаргах, ажлын зурагт оруулах, Аврагчийн худрага, дуулга, бээлий, олсоор авирах, буух хэрэгсэл ашиглан 10 метр өндөр цамхагруу 3 минутанд авирч, буух техник, Аврах ажиллагааны 3 төрлийн зангилааг уяж, хэрэглээ, зориулалтыг тайлбарлах; Усанд сэлэлтийн өврөөр даллах төрлөөр 50 метр сэлэх</p> |
| | <p>Гал түймэр унтраах, аврах ангийн офицер</p> | <p>Гал түймэр унтраах дүрэм, Онцгой байдлын байгууллагын хэмжээнд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм, Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, Эмнэлгийн анхны тусламж</p> | <p>I зэрэг: ОБЕГ-ын даргын 2013 оны 12 дугаар тушаалын дагуу хөдөлмөр хамгааллын хувцас өмсөх, гал унтраах дасгал сургуулиар хийж гүйцэтгэх шалгалтад “А” үнэлгээтэй дүгнэгдэх, Томьёолсон тэмдгээр гал унтраах тархалт хийх схем зураг зурах, 43 секундэд “Б” хушуу 2 ширхэг, “А” хушуу 1 ширхэг, ажлын шугам тус бүр 40 метр, төв шугам 20 метр, 3 сунадаг шаттай цамхагийн 2 давхарт, 43 секундэд “Б” хушуу 2 ширхэг, “А” хушуу 1 ширхэг, ажлын шугам тус бүр 40 метр, төв шугам 20 метр, довтолгооны шаттай цамхагийн 2 давхарт, Усанд сэлэлтийн өврөөр даллах төрлөөр 25 метр сэлэх</p> <p>II зэрэг: ОБЕГ-ын даргын 2013 оны 12 дугаар тушаалын дагуу хөдөлмөр хамгааллын хувцас өмсөх, гал унтраах дасгал сургуулиар хийж гүйцэтгэх шалгалтад “В” үнэлгээтэй дүгнэгдэх, Томьёолсон тэмдгээр гал унтраах тархалт хийх схем зураг зурах, 46 секундэд “Б” хушуу 2 ширхэг, “А” хушуу 1 ширхэг, ажлын шугам тус бүр 40 метр, төв шугам 20 метр, 3 сунадаг шаттай цамхагийн 2 давхарт, 46 секундэд “Б” хушуу 2 ширхэг, “А” хушуу 1 ширхэг, ажлын шугам тус бүр 40 метр, төв шугам 20 метр, довтолгооны шаттай цамхагийн 2 давхарт, Усанд сэлэлтийн мэлхий төрлөөр 25 метр сэлэх</p> <p>III зэрэг:</p> |

| | | | |
|---|--|---|---|
| | | | <p>ОБЕГ-ын даргын 2013 оны 12 дугаар тушаалын дагуу хөдөлмөр хамгааллын хувцас өмсөх, гал унтраах дасгал сургуулиар хийж гүйцэтгэх шалгалтад "С" үнэлгээтэй дүгнэгдэх, Томьёолсон тэмдгээр гал унтраах тархалт хийх схем зураг зурах, 49 секундэд "Б" хушуу 2 ширхэг, "А" хушуу 1 ширхэг, ажлын шугам тус бүр 40 метр, төв шугам 20 метр, 3 сунадаг шаттай цамхагийн 2 давхарт, 49 секундэд "Б" хушуу 2 ширхэг, "А" хушуу 1 ширхэг, ажлын шугам тус бүр 40 метр, төв шугам 20 метр, довтолгооны шаттай цамхагийн 2 давхарт, Усанд сэлдэг байх</p> |
| <p>Нөөцийн чиглэлийн офицер</p> | | <p>"Улсын нөөцийн бараа, материал хүлээн авах, хадгалах, зарцуулах, тооллого хийх, тооцоо бодох журам" "Улсын нөөцийн бараа, материалын удаан хадгалах журам", "Улсын нөөцийн бараа, материалыг ачих, буулгахад гар ажиллагаатай ажлын үнэлгээ"</p> | <p>I зэрэг: Баримт бичиг боловсруулах ур чадвар, Барааны чанар стандартын мэдлэг, ур чадвар Бараа, материалын хадгалалтын онцлогийн талаархи ур чадвар Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах Хөдөлмөр хамгаалалын багаж хэрэгсэлтэй ажиллах ур чадвар Усанд сэлэлтийн өврөөр даллах төрлөөр 25 метр сэлэх II зэрэг: Баримт бичиг боловсруулах ур чадвар, Бараа, материалын хадгалалтын онцлогийн талаархи ур чадвар Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах Хөдөлмөр хамгаалалын багаж хэрэгсэлтэй ажиллах ур чадвар Усанд сэлэлтийн мэлхий төрлөөр 25 метр сэлэх III зэрэг: Барааны чанар стандартын мэдлэг, ур чадвар Бараа, материалын хадгалалтын онцлогийн талаархи ур чадвар Хөдөлмөр хамгаалалын багаж хэрэгсэлтэй ажиллах ур чадвар</p> |
| <p>Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч</p> | | <p>Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, Эмнэлгийн анхны тусламж</p> | <p>I зэрэг: Баримт бичиг боловсруулах ур чадвар, Байр зүйн зураг зурах, ажиллах, GPS төхөөрөмж ашиглан тодорхой хугацаанд цэгийг олох, Хүн нэг бүрийн хамгаалах (ОП-1) хэрэгслийг 3 минутанд өмсөх,</p> |

| | | |
|--|---|--|
| <p>Гал түймрийн Улсын Хяналтын Байцаагч</p> | | <p>Аврах олсоор дан давхар (эр, эм) уяаг 10 секундэд уях, Байцаагчийн ажлын дундаж үзүүлэлтээр “А” дүгнэгдсэн, Усанд сэлэлтийн өврөөр даллах төрлөөр 25 метр сэлэх</p> <p>II зэрэг: Баримт бичиг боловсруулах ур чадвар, Байр зүйн зурагтай ажиллах, Хүн нэг бүрийн хамгаалах (ОП-1) хэрэгслийг 3 минут, 20 секундэнд өмсөх, Аврах олсоор дан давхар (эр, эм) уяаг 15 секундэд уях, Байцаагчийн ажлын дундаж үзүүлэлтээр “В” түүнээс дээш дүгнэгдсэн, Усанд сэлэлтийн мэлхий төрлөөр 25 метр сэлэх</p> <p>III зэрэг: Баримт бичиг боловсруулах ур чадвар, Байр зүйн зураг унших, Хүн нэг бүрийн хамгаалах (ОП-1) хэрэгслийг 4 минутанд өмсөх, Аврах олсоор дан давхар (эр, эм) уяаг 20 секундэд уях, Байцаагчийн ажлын дундаж үзүүлэлтээр “С” түүнээс дээш дүгнэгдсэн, Усанд сэлдэг байх</p> |
| <p>Гал түймрийн Улсын Хяналтын Байцаагч</p> | <p>Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, Эмнэлгийн анхны тусламж</p> | <p>I зэрэг: Баримт бичиг боловсруулах ур чадвар, Байр зүйн зураг зурах, ажиллах, GPS төхөөрөмж ашиглан тодорхой хугацаанд цэгийг олох, Хүн нэг бүрийн хамгаалах (ОП-1) хэрэгслийг 3 минутанд өмсөх, Аврах олсоор дан давхар (эр, эм) уяаг 10 секундэд уях, Байцаагчийн ажлын дундаж үзүүлэлтээр “А” дүгнэгдсэн, Усанд сэлэлтийн өврөөр даллах төрлөөр 25 метр сэлэх</p> <p>II зэрэг: Баримт бичиг боловсруулах ур чадвар, Байр зүйн зурагтай ажиллах, Хүн нэг бүрийн хамгаалах (ОП-1) хэрэгслийг 3 минут, 20 секундэнд өмсөх,</p> |

| | | | |
|---|--|---|---|
| | | | <p>Аврах олсоор дан давхар (эр, эм) уяаг 15 секундэд уях, Байцаагчийн ажлын дундаж үзүүлэлтээр "В" түүнээс дээш дүгнэгдсэн, Усанд сэлэлтийн мэлхий төрлөөр 25 метр сэлэх III зэрэг.</p> <p>Баримт бичиг боловсруулах ур чадвар, Байр зүйн зураг унших, Хүн нэг бүрийн хамгаалах (ОП-1) хэрэгслийг 4 минутанд өмсөх, Аврах олсоор дан давхар (эр, эм) уяаг 20 секундэд уях, Байцаагчийн ажлын дундаж үзүүлэлтээр "С" түүнээс дээш дүгнэгдсэн, Усанд сэлдэг байх</p> |
| <p>Холбоо, зарлан мэдээллийн чиглэлийн офицер</p> | | <p>Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, Эмнэлгийн анхны тусламж, Онцгой байдлын байгууллагад ашиглагдаж байгаа бүх төрлийн холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслийн зориулалт, тактик техникийн өгөгдөхүүн, цахим бүртгэлийн систем, байр зүйн зураг, газарзүйн мэдээллийн систем, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн технологийн нийтлэг мэдлэг, холбооны тоног төхөөрөмж дээр ажиллах аюулгүй ажиллагааны шаардлага, холбоо, мэдээллийн үндсэн нэр томъёоны тодорхойлолт</p> | <p>I зэрэг:</p> <p>Богино долгионы IC-78 загварын радио станцыг 4 минутын хугацаанд өгөгдсөн үелзэлд тохируулж ажилд бэлдэх, Хэт богино долгионы VX-150 загварын радио станцыг 2 минутын хугацаанд өгөгдсөн үелзэлд тохируулж ажилд бэлдэх, Зарлан мэдээллийн дуут дохиоллын цамхгийг 4 минутын хугацаанд ажилд бэлдэж холбоонд орох, Радио станцын тэжээлийн гэмтлийг 5 минутын хугацаанд илрүүлэх, Антен-фидерийн байгууламжийн гэмтлийг 5 минутын хугацаанд илрүүлэх, Байршил тодорхойлогч ашиглан өгөгдсөн цэгийг тодорхойлж, байр зүйн зурагт 4 минутын хугацаанд тэмдэглэх, Усанд сэлэлтийн өврөөр даллах төрлөөр 25 метр сэлэх II зэрэг:</p> <p>Богино долгионы IC-78 загварын радио станцыг 6 минутын хугацаанд өгөгдсөн үелзэлд тохируулж ажилд бэлдэх, Хэт богино долгионы VX-150 загварын радио станцыг 4 минутын хугацаанд өгөгдсөн үелзэлд тохируулж ажилд бэлдэх, Зарлан мэдээллийн дуут дохиоллын цамхгийг 6 минутын хугацаанд ажилд бэлдэж холбоонд орох,</p> |

| | | |
|----------------------------------|--|---|
| | | <p>Радио станцын тэжээлийн гэмтлийг 8 минутын хугацаанд илрүүлэх, Антен-фидерийн байгууламжийн гэмтлийг 8 минутын хугацаанд илрүүлэх, Байршил тодорхойлогч ашиглан өгөгдсөн цэгийг тодорхойлж, байр зүйн зурагт 8 минутын хугацаанд тэмдэглэх, Усанд сэлэлтийн мэлхий төрлөөр 25 метр сэлэх III зэрэг:</p> <p>Богино долгионы IC-78 загварын радио станцыг 8 минутын хугацаанд өгөгдсөн үелзэлд тохируулж ажилд бэлдэх, Хэт богино долгионы VX-150 загварын радио станцыг 6 минутын хугацаанд өгөгдсөн үелзэлд тохируулж ажилд бэлдэх, Зарлан мэдээллийн дуут дохиоллын цамхгийг 8 минутын хугацаанд ажилд бэлдэж холбоонд орох, Радио станцын тэжээлийн гэмтлийг 11 минутын хугацаанд илрүүлэх, Антен-фидерийн байгууламжийн гэмтлийг 11 минутын хугацаанд илрүүлэх, Байршил тодорхойлогч ашиглан өгөгдсөн цэгийг тодорхойлж, байр зүйн зурагт 12 минутын хугацаанд тэмдэглэх, Усанд сэлдэг байх</p> |
| <p>Гүйцэтгэх албан тушаалтан</p> | <p>Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, Эмнэлгийн анхны тусламж</p> | <p>I зэрэг:</p> <p>Хүн нэг бүрийн хамгаалах (ОП-1) хэрэгслийг 3 минутанд өмсөх, Аврах олсоор дан давхар (эр, эм) уяаг 10 секундэд уях, Усанд сэлэлтийн өврөөр даллах төрлөөр 25 метр сэлэх II зэрэг:</p> <p>Хүн нэг бүрийн хамгаалах (ОП-1) хэрэгслийг 3 минут, 20 секундэнд өмсөх, Аврах олсоор дан давхар (эр, эм) уяаг 15 секундэд уях, Усанд сэлэлтийн мэлхий төрлөөр 25 метр сэлэх III зэрэг:</p> <p>Хүн нэг бүрийн хамгаалах (ОП-1) хэрэгслийг 4 минутанд өмсөх, Аврах олсоор дан давхар (эр, эм) уяаг 20 секундэд уях,</p> |

| | | |
|--------------------|---|---|
| | | <p>Усанд сэлдэг байх</p> <p>I зэрэг: Аврах олс, түгжээтэй гогцоо /карбин/, олс гүйлгэгч, баавгайн савар /салаалагч/ дугуйтай дамар ашиглан 1 тонн ачааг 5 минутанд 2 метр газар татах Аврах ажиллагааны 8 төрлийн зангилааг уяж, хэрэглээ, зориулалтыг тайлбарлах, Хүн нэг бүрийн хамгаалах (ОП-1) хэрэгслийг 3 минутанд өмсөх, Усны гүнд 25 метр шумбах, живж буй иргэнийг аврах</p> <p>II зэрэг: Аврагчийн худрага, дуулга, бээлий, олсоор авирах, буух хэрэгсэл ашиглан 10 метр өндөр цамхагруу авирч, нэрвэгдэгчийг биедээ бэхэлж 5 минутанд буулгах техник, Аврах ажиллагааны 5 төрлийн зангилааг уяж, хэрэглээ, зориулалтыг тайлбарлах, Хүн нэг бүрийн хамгаалах (ОП-1) хэрэгслийг 3 минут, 20 секундэнд өмсөх, Усанд сэлэлтийн өврөөр даллах төрлөөр 100 метр сэлэх</p> <p>III зэрэг: Аврагчийн худрага, дуулга, бээлий, олсоор авирах, буух хэрэгсэл ашиглан 10 метр өндөр цамхагруу 3 минутанд авирч, буух техник, Аврах ажиллагааны 3 төрлийн зангилааг уяж, хэрэглээ, зориулалтыг тайлбарлах, Хүн нэг бүрийн хамгаалах (ОП-1) хэрэгслийг 4 минутанд өмсөх, Усанд сэлэлтийн өврөөр даллах төрлөөр 50 метр сэлэх</p> |
| <p>Аврагч</p> | <p>Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журам, Онцгой байдлын байгууллагын хэмжээнд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм</p> | <p>I зэрэг: ОБЕГ-ын даргын 2013 оны 12 дугаар тушаалын дагуу гал сөнөөгч нэг бүрийн хөдөлмөр хамгааллын хувцасыг (дулааны болон хүйтний улирал) өмсөх, гал унтраах дасгал сургуулиар хийж гүйцэтгэх шалгалтад "А" үнэлгээтэй дүгнэгдэх, Араатай шатыг цамхагийн 2 давхарт 30 метр зайнаас барьж гүйн 10 секундэд өлгөж оролт хийх, Аврах олсоор дан давхар /эр эм/ уяаг 6 секундэд уях,</p> |
| <p>Гал сөнөөгч</p> | <p>Гал түймэр унтраах дүрэм, Онцгой байдлын байгууллагын хэмжээнд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, Эмнэлгийн анхны тусламж</p> | |

| | | | |
|--|--------------------------------------|--|--|
| | | | <p>Усанд сэлэлтийн өврөөр даллах төрлөөр 25 метр сэлэх</p> <p>II зэрэг:</p> <p>ОБЕГ-ын даргын 2013 оны 12 дугаар тушаалын дагуу гал сөнөөгч нэг бүрийн хөдөлмөр хамгааллын хувцасыг (дулааны болон хүйтний улирал) өмсөх, гал унтраах дасгал сургуулиар хийж гүйцэтгэх шалгалтад "В" үнэлгээтэй дүгнэгдэх, Араатай шатыг цамхагийн 2 давхарт 30 метр зайнаас барьж гүйн 12 секундэд өлгөж оролт хийх, Аврах олсоор дан давхар /эр эм/ уяаг 7 секундэд уях,</p> <p>Усанд сэлэлтийн мэлхий төрлөөр 25 метр сэлэх</p> <p>III зэрэг:</p> <p>ОБЕГ-ын даргын 2013 оны 12 дугаар тушаалын дагуу гал сөнөөгч нэг бүрийн хөдөлмөр хамгааллын хувцасыг (дулааны болон хүйтний улирал) өмсөх, гал унтраах дасгал сургуулиар хийж гүйцэтгэх шалгалтад "С" үнэлгээтэй дүгнэгдэх, Араатай шатыг цамхагийн 2 давхарт 30 метр зайнаас барьж гүйн 14 секундэд өлгөж оролт хийх, Аврах олсоор дан давхар /эр эм/ уяаг 9 секундэд уях,</p> <p>Усанд сэлдэг байх</p> |
| | <p>Гал унтраах автомашины жолооч</p> | <p>Гал түймэр унтраах дүрэм, Онцгой байдлын байгууллагын хэмжээнд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, Эмнэлгийн анхны тусламж</p> | <p>I зэрэг:</p> <p>ОБЕГ-ын даргын 2013 оны 12 дугаар тушаалын дагуу хөдөлмөр хамгааллын хувцас өмсөх, гал унтраах дасгал сургуулиар хийж гүйцэтгэх шалгалтад "А" үнэлгээтэй дүгнэгдэх, Гал унтраах автомашиныг 500 литр савтай уснаас 125 мм хоолойг 75 секундэд сорох шүүртэй бүрэн холбох, Тээврийн хэрэгслийн гэмтэл олох,</p> <p>Усанд сэлэлтийн өврөөр даллах төрлөөр 25 метр сэлэх</p> <p>II зэрэг:</p> <p>ОБЕГ-ын даргын 2013 оны 12 дугаар тушаалын дагуу хөдөлмөр хамгааллын хувцас өмсөх, гал унтраах дасгал сургуулиар хийж гүйцэтгэх шалгалтад "В" үнэлгээтэй дүгнэгдэх, Гал унтраах автомашиныг 500 литр савтай уснаас 125 мм хоолойг 80 секундэд сорох шүүртэй бүрэн холбох,</p> |

| | | | |
|-------------|---------------|--|---|
| | | | <p>Тээврийн хэрэгслийн гэмтэл олох, Усанд сэлэлтийн мэлхий төрлөөр 25 метр сэлэх III зэрэг: ОБЕГ-ын даргын 2013 оны 12 дугаар тушаалын дагуу хөдөлмөр хамгааллын хувцас өмсөх, гал унтраах дасгал сургуулиар хийж гүйцэтгэх шалгалтад "С" үнэлгээтэй дүгнэгдэх, Гал унтраах автомашиныг 500 литр савтай уснаас 125 мм хоолойг 90 секундэд сорох шүүртэй бүрэн холбох, Тээврийн хэрэгслийн гэмтэл олох, Усанд сэлдэг байх</p> |
| <p>1 2.</p> | <p>Жолооч</p> | <p>Онцгой байдлын байгууллагын хэмжээнд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, Эмнэлгийн анхны тусламж</p> | <p>I зэрэг: Тээврийн хэрэгслийн гэмтэл олох, Тээврийн хэрэгслийг 90 грудаст 1 үйлдлээр ухрааж байрлуулах, Тээврийн хэрэгслийг 45 градуст буюу хажуугийн зогсоолд 1 үйлдлээр ухрааж байрлуулах, Тээврийн хэрэгслийг эгц өгсүүр газарт авцуулах холбооны тусламжтайгаар өгсөх үйлдэл хийх, Тээврийн хэрэгслийг хойш авцуулах холбоогүйгээр өнхрүүлэх /алдах/ үйлдэл хийвэл тооцохгүй, Усанд сэлэлтийн өврөөр даллах төрлөөр 25 метр сэлэх II зэрэг: Тээврийн хэрэгслийн гэмтэл олох, Тээврийн хэрэгслийг 90 грудаст 2 үйлдлээр ухрааж байрлуулах, Тээврийн хэрэгслийг 45 градуст буюу хажуугийн зогсоолд 2 үйлдлээр ухрааж байрлуулах, Тээврийн хэрэгслийг эгц өгсүүр газарт авцуулах холбооны тусламжтайгаар өгсөх үйлдэл хийх, Тээврийн хэрэгслийг хойш авцуулах холбоогүйгээр өнхрүүлэх /алдах/ үйлдэл хийвэл тооцохгүй, Усанд сэлэлтийн мэлхий төрлөөр 25 метр сэлэх III зэрэг: Тээврийн хэрэгслийн гэмтэл олох, Тээврийн хэрэгслийг 90 грудаст 3 үйлдлээр ухрааж байрлуулах,</p> |

| | | | |
|---|--|---|--|
| | | | <p>Тээврийн хэрэгслийг 45 градуст буюу хажуугийн зогсоолд 3 үйлдлээр ухрааж байрлуулах, Тээврийн хэрэгслийг эгц өгсүүр газарт авцуулах холбооны тусламжтайгаар өгсөх үйлдэл хийх, Тээврийн хэрэгслийг хойш авцуулах холбоогүйгээр өнхрүүлэх /алдах/ үйлдэл хийвэл тооцохгүй, Усанд сэлдэг байх</p> |
| <p>Холбоо, зарлан мэдээллийн чиглэлийн ахлагч</p> | <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, Эмнэлгийн анхны тусламж, Онцгой байдлын байгууллагад ашиглагдаж байгаа зарим төрлийн холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслийн зориулалт, тактик техникийн өгөгдөхүүн, томъёолсон тэмдэг, тэмдэглэгээ, цахим бүртгэлийн систем, мэдээллийн технологийн нийтлэг мэдлэг, холбооны тоног төхөөрөмж дээр ажиллах аюулгүй ажиллагааны шаардлага, холбоо, мэдээллийн үндсэн нэр томъёоны тодорхойлолт, Эмнэлгийн анхны тусламж</p> | <p>I зэрэг: Богино долгионы IC-78 загварын радио станцыг 6 минутын хугацаанд өгөгдсөн үелзэлд тохируулж ажилд бэлдэх. Хэт богино долгионы VX-150 загварын радио станцыг 6 минутын хугацаанд өгөгдсөн үелзэлд тохируулж ажилд бэлдэх. Зарлан мэдээллийн дуут дохиоллын цамхгийг 6 минутын хугацаанд ажилд бэлдэж холбоонд орох Радио станцын тэжээлийн гэмтлийг 10 минутын хугацаанд илрүүлэх Антен-фидерийн байгууламжийн гэмтлийг 10 минутын хугацаанд илрүүлэх Байршил тодорхойлогч ашиглан өгөгдсөн цэгийг 2 минутын хугацаанд тодорхойлох, Усанд сэлэлтийн өврөөр даллах төрлөөр 25 метр сэлэх II зэрэг: Богино долгионы IC-78 загварын радио станцыг 8 минутын хугацаанд өгөгдсөн үелзэлд тохируулж ажилд бэлдэх. Хэт богино долгионы VX-150 загварын радио станцыг 8 минутын хугацаанд өгөгдсөн үелзэлд тохируулж ажилд бэлдэх. Зарлан мэдээллийн дуут дохиоллын цамхгийг 9 минутын хугацаанд ажилд бэлдэж холбоонд орох Радио станцын тэжээлийн гэмтлийг 13 минутын хугацаанд илрүүлэх Антен-фидерийн байгууламжийн гэмтлийг 13 минутын хугацаанд илрүүлэх</p> | |

| | | | |
|-------------------------------|---|--|---|
| | | | <p>Байршил тодорхойлогч ашиглан өгөгдсөн цэгийг 4 минутын хугацаанд тодорхойлох, Усанд сэлэлтийн мэлхий төрлөөр 25 метр сэлэх III зэрэг:</p> <p>Богино долгионы IC-78 загварын радио станцыг 10 минутын хугацаанд өгөгдсөн үелзэлд тохируулж ажилд бэлдэх. Хэт богино долгионы VX-150 загварын радио станцыг 10 минутын хугацаанд өгөгдсөн үелзэлд тохируулж ажилд бэлдэх. Зарлан мэдээллийн дуут дохиоллын цамхгийг 12 минутын хугацаанд ажилд бэлдэж холбоонд орох Радио станцын тэжээлийн гэмтлийг 16 минутын хугацаанд илрүүлэх Антен-фидерийн байгууламжийн гэмтлийг 16 минутын хугацаанд илрүүлэх Байршил тодорхойлогч ашиглан өгөгдсөн цэгийг 6 минутын хугацаанд тодорхойлох, Усанд сэлдэг байх</p> |
| <p>Туслах албан тушаалтан</p> | <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, Эмнэлгийн анхны тусламж</p> | | <p>I зэрэг:</p> <p>Хүн нэг бүрийн хамгаалах (ОП-1) хэрэгслийг 3 минутанд өмсөх, Аврах олсоор дан давхар (эр, эм) уяаг 20 секундэд уях, Усанд сэлэлтийн өврөөр даллах төрлөөр 25 метр сэлэх II зэрэг:</p> <p>Хүн нэг бүрийн хамгаалах (ОП-1) хэрэгслийг 3 минут, 20 секундэнд өмсөх, Аврах олсоор дан давхар (эр, эм) уяаг 30 секундэд уях, Усанд сэлэлтийн мэлхий төрлөөр 25 метр сэлэх III зэрэг:</p> <p>Хүн нэг бүрийн хамгаалах (ОП-1) хэрэгслийг 4 минутанд өмсөх, Аврах олсоор дан давхар (эр, эм) уяаг 40 секундэд уях, Усанд сэлдэг байх</p> |

Тав. Мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох:

Мэргэшлийн зэрэг буурсан алба хаагчийн зэргийн нэмэгдлийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар дараа сарын 01-ний өдрөөс бууруулж олгоно. Мэргэшлийн зэрэг олгох, ахиулах шалгалтад тэнцсэн алба хаагчийн зэргийн нэмэгдлийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар олгоно.

Зургаа. Мэргэшлийн зэргийн шалгалтад орох алба хаагчийн бүрдүүлэх баримт бичиг:

- Мэргэшлийн зэргийн шалгалтад орох хүсэлт, (Маягт-1)
- Төрийн алба хаагчийн өмнөх жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт (ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ) “С” буюу хангалттай эсхүл түүнээс дээш үнэлгээтэй дүгнэгдсэнийг илтгэх баримт;
- Шалгалт авахаас өмнөх 1 жилийн хугацаанд сахилгын шийтгэл хүлээж байгаагүй; (сахилгын шийтгэл хугацаанаас өмнө арилгах хамаарахгүй)
- Эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж, тэнцсэн тухай нотлох баримт (сүүлийн 3 сарын хугацаанд хамрагдсан байх)

Долоо. Хариуцлага:

Мэргэшлийн зэргийн шалгалттай холбоотой маргааныг шалгалтын комисс шийдвэрлэнэ. Шалгалттай холбогдолтой баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн холбогдох албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль болон Цэргийн сахилгын дүрэмд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---ooOoo---

Мэргэшлийн зэргийн шалгалтад орох хүсэлт

1. Овог:
2. Нэр:
3. Цол:
4. Харьяа байгууллага:
5. Харьяа нэгж:
6. Албан тушаал:
7. Төрсөн он, сар, өдөр:
8. Нас:
9. Хүйс:
10. Онцгой байдлын байгууллагад орсон он, сар, өдөр:
11. Онцгой байдлын байгууллагад ажилласан жил:
12. Шалгалт авахаас өмнөх 1 жилийн хугацаанд сахилгын шийтгэл:
 - А. хүлээж байгаагүй
 - Б. хүлээж байсан
13. Төрийн алба хаагчийн өмнөх жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт:
(ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ)
... буюу ... үнэлгээтэй дүгнэгдсэн.
14. Эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж тэнцсэн эсэх: (эрүүл мэндийн хуудсыг хавсаргах)
 - А. тэнцсэн
 - Б. тэнцээгүй

Хүсэлт гаргасан:

..... /Гарын үсгийн тайлал/

20 ... оны ... сарын ... -ны өдөр